

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАР ЗЭРЭГ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БУС МАШИН, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТҮЛХҮҮ БАЙДЛААР ТУСГАЖ БАЙГАА НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨН ЧАНАР, ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ

АУДИТЫН КОД: СЭА-2021/02-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум	Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	
	Утас: 70363040	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
2021 он	Аудитын менежер	Б.Батмөнх
	Утас: 70363036	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор	Т.Болор
	Утас: 70362442	Цахим хаяг: Bolort@audit.gov.com
	Аудитор З.Золбоо	Цахим хаяг: Zolbooz@audit.gov.mn
	Аудитор Т.Одсүрэн	Цахим хаяг: Odsuren.t@audit.gov.mn



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/08

Сүхбаатар

Аудитын тайлан, дүнг батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4, 37 дугаар зүйлийн 37.2, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчил, зөрчлийг арилгах албан шаардлагын дүнг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга Б.Нарантуяа, Засаг дарга Ш.Оргил, ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа, ОНӨГ-ын дарга П.Эрдэнэсайхан болон сумдын Засаг дарга нарт хүргүүлж, www.audit.mn цахим хуудсаар нийтэд мэдээлсүгэй.

4. Аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Батмөнх/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

018010032

2021 оны 07 дугаар сарын 09 өдрийн
1108 дугаар тушаалын хавсралт



АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

/ сая төгрөг/

№	Төлбөр, зөрчлийн утга	Нийт зөрчлийн дүн	Албан шаардлага
1	Зураг төсөв, тооцоо судалгаа нь урьдчилан хийгдээгүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн.	422.3	422.3
2	Зураг, төсөв тооцоо судалгаа нь урьдчилан хийгдээгүй төсөл, арга хэмжээг төсвийн тодотголоор нэмж баталсан.	1,200.1	1,200.1
3	Төсөл арга хэмжээний зураг, төсөвт магадлал хийлгээгүй.	1,011.4	1,011.4
4	"Хүлээн авсан комиссын акт" үйлдээгүй буюу баримтын бүрдэл дутуу төсөл арга хэмжээний санхүүжилтийн гүйлгээг гүйцэтгэж бүртгэл, тайланд тусгасан.	85.9	85.9
5	Тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.	35.0	35.0
6	Захиалагчийн саналыг харгалзалгүйгээр техникийн тодорхойлолтыг боловсруулсан, тавигдах шаардлагыг бүрэн тусгаагүй.	28.0	28.0
7	Шууд худалдан авах босго үнээс давсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн.	33.6	33.6
Нийт дүн		2,816.3	2,816.3

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Дүрслэлийн товъёг	4
Хавсралтын товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5
Ерөнхий мэдээлэл	6
Нэгдүгээр бүлэг: Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого боловсруулаагүй бөгөөд төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.	7
1.1 Аймаг, сумд нь төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого боловсруулаагүй байна.	7
1.2 Тооцоо судалгааг урьдчилан хийгээгүй, зураг төсөвгүй, зураг төсөвт магадлал хийлгээгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.	10
Хоёрдугаар бүлэг: Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 1,935.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 38 төсөл, арга хэмжээ дутуу болон огт хэрэгжээгүй байна.	12
2.1 Тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.	12
2.2 Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 61.2 хувийг бүрэн хэрэгжүүлсэн байна.	15
2.3 Зарим төсөл, арга хэмжээний зураг, төсөвт зохиогчийн хяналтын гэрээ байгуулаагүй, ажил хүлээж авах комиссын бүрэлдэхүүнд зохиогчийг ажиллуулаагүй байна.	19
Аудитын дүгнэлт	21
Зөвлөмж	22
Ирүүлсэн санал, тайлбар	24
Төрийн аудитын газрын тайлбар	25
Хавсралт	26

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЭА	Сэлэнгэ аймаг
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШТА	Шууд тайлагнах аудит
ЭЗНХҮЧ	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

Хүснэгтийн товьёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орон нутгийн төсвийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө	7
Хүснэгт 2	Хөрөнгө оруулалтын бус урсгал зардлын шинж чанартай төсөл, арга хэмжээ	12
Хүснэгт 3	Он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт	15
Хүснэгт 4	Нэмэлт гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээ	17
Хүснэгт 5	Магадалшгүй ажлын зардлыг хурлын тэмдэглэл, хийгдсэн ажлыг баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэлийг үндэслэлгүйгээр олгосон төсөл, арга хэмжээ	17
Хүснэгт 6	“Хүлээн авсан комиссын акт” үйлдэхгүйгээр санхүүжилтийг олгосон төсөл, арга хэмжээ	18

Дүрслэлийн товьёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл, арга хэмжээнд аймаг, сумдын хөрөнгө оруулалтын эзлэх хувь	8
Дүрслэл 2	Аймгийн төсвийн хөрөнгөөр 2018-2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн харьцуулалт	9
Дүрслэл 3	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2018-2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний бүтэц	10
Дүрслэл 4	Шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, тоо хэмжээнд эзлэх хувийн харьцуулалт	11
Дүрслэл 5	Худалдан авах ажиллагааны харьцуулалт	13
Дүрслэл 6	Шинээр эхлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн харьцуулалт	16
Дүрслэл 7	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний харьцуулалт	20

Хавсралтын товьёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Аймгийн төсвийн болон замын сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт	26-27
Хавсралт 2	Сумдын төсвийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт	28-29
Хавсралт 3	Зураг төсөв, тооцоо судалгаа нь урьдчилан хийгдээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт	30
Хавсралт 4	Төсвийн тодотголоор зураг, төсөв, тооцоо судалгаагүй төсөл арга хэмжээг нэмж баталсан жагсаалт	31
Хавсралт 5	2020 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээнд зураг төсөв, магадлал, ажлын даалгавар хийлгэсэн жагсаалт	32
Хавсралт 6	Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 10.0 сая төгрөгөөс доош төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний жагсаалт	33
Хавсралт 7	Замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах эрхийг сумдын Засаг дарга нарт шилжүүлсэн төсөл, арга хэмжээний жагсаалт	34
Хавсралт 8	Аймгийн ОНӨГ-аас аймгийн ТЭЗ-ийн 2020 оны худалдан авах бараа, ажил үйлчилгээний жилийн эцсийн тайланд зөрүүтэй тайлагнасан төсөл, арга хэмжээний жагсаалт	35
Хавсралт 9	Захиалагчийн хяналт огт хийгдээгүй төсөл, арга хэмжээний жагсаалт	36
Хавсралт 10	Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	37

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” А/28 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг албан тушаалтнуудад танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Зорилтыг хангахын тулд дараах дэд асуудлын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: ➤ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт үр нөлөөтэй байна уу? ➤ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр ашигтай байна уу?
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг хүлээсэн аймаг, сумдын Засаг дарга, ЗДТГ, ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ, аймгийн ОНӨГ, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ болон холбогдох бусад байгууллагын баримт материалыг хамруулав.
Аудитын арга зүй:	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020, MNS 6817-5:2020, MNS 6817-7:2020, стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийж журам”-д заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитад дараах хууль эрх зүйн актыг гол шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд: • Төсвийн тухай хууль • Барилгын тухай хууль • Авто замын тухай хууль • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

	• Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр • Сэлэнгэ аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл • Дээрх хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад шийдвэрүүд.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Т.Болор, аудитор З.Золбоо, Т.Одсүрэн нар 2021 оны 5 дугаар сарын 15-наас 2021 оны 07 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэв.
Ерөнхий мэдээлэл:	Сэлэнгэ аймагт 2020 онд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,457.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 24 төсөл, арга хэмжээ, замын сангийн хөрөнгөөр 811.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээ, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,903.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 57 төсөл, арга хэмжээ зэрэг нийт 4,173.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 98 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. 2020 онд шинээр хэрэгжих нийт 3,284.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 92 төсөл, арга хэмжээнээс 1,538.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 57 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 370.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 9 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн бол 1,375.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 26 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

Нэгдүгээр бүлэг

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт үр нөлөөтэй байна уу?

Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого боловсруулаагүй бөгөөд төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого боловсруулж, түүний хүрээнд төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан уу?

Аймаг, сумд нь төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого боловсруулаагүй байна.

1.1.1 Аймгийн хөрөнгө оруулалтаар 1,457.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 24 төсөл, арга хэмжээ, замын сангийн хөрөнгөөр 811.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 17 төсөл, арга хэмжээ, сумдын хөрөнгө оруулалтаар 1,903.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 57 төсөл, арга хэмжээ зэрэг нийт 4,173.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 98 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг сумдын ИТХ-аар баталсан байна.

1.1.2 Орон нутгийн төсвийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг харьцуулан харуулбал:

Хүснэгт № 1 / сая төгрөг /

№	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Анх баталсан тогтоолоор		Эцэслэж баталсан тогтоолоор	
		Тоо	Төсөвт өртөг	Тоо	Төсөвт өртөг
1	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын дүн	18	1,249.8	24	1,457.7
2	Баруунбүрэн сум	1	28.0	1	28.0
3	Баянгол сум	1	13.0	2	18.6
4	Ерөө сум	2	56.8	19	1,064.3
5	Мандал сум	5	236.5	12	510.0
6	Орхон сум	2	13.3	2	13.3
7	Сайхан сум	2	42.0	3	58.1
8	Сүхбаатар сум	8	118.0	10	118.0
9	Цагааннуур сум	3	63.0	3	63.0
10	Шаамар сум	6	43.0	5	30.3
	Сумдын хөрөнгө оруулалтын дүн	30	613.6	57	1,903.6
11	Замын сангийн хөрөнгө оруулалтын дүн	19	851.7	17	811.7
	Дүн	67	2,715.0	98	4,173.0

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол.

1.1.3 Аймгийн ИТХ-ын 2019 оны 70 дугаар тогтоолоор 2020 оны аймгийн

төсвийн хөрөнгө оруулалтаар 1,249.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бол 2020 оны 77 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж, 1,457.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 24 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр эцэслэн баталсан байна. /Хавсралт №1-д дэлгэрэнгүй харуулав./


1.1.4 Сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар 613.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 30 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр анх баталсан бол төсвийн тодотголоор 27 төсөл арга хэмжээг нэмэгдүүлж, нийт 1,903.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 57 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр эцэслэн баталсан байна. /Хавсралт №2-т дэлгэрэнгүй харуулав./

1.1.5 Харин Цагааннуур сум нь хөрөнгө оруулалтын шинж чанартай 63.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд бус сумын ЗДТГ-ын хөрөнгийн зардалд баталсан байна.

1.1.6 Замын сангийн хөрөнгө оруулалтаар 851.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 19 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр анх баталсан бол төсвийн тодотголоор 811.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр эцэслэн баталсан байна. /Хавсралт №1-д дэлгэрэнгүй харуулав./

1.1.7 Орон нутгийн төсвийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт төсөл, арга хэмжээнд аймаг, сумдын хөрөнгө оруулалтын эзлэх хувийг дүрслэлээр харуулбал дараах байдалтай байна.

Дүрслэл №1 / төсөл, арга хэмжээгээр /



Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол

1.1.8 Нийт хөрөнгө оруулалтын төсөвт өртгийн 34.9 хувийг аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, 25.5 хувийг Ерөө сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, 19.5 хувийг замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ эзэлж байна.

1.1.9 Аймаг, сумд нь төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, дунд болон урт хугацааны төлөвлөгөө боловсруулаагүй бөгөөд төсөл, арга хэмжээг хэрэгцээ шаардлага, үр ашиг, тэргүүлэх чиглэл, ач холбогдлоор нь эрэмбэлээгүй, Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2020 оны үндсэн чиглэлтэй нийцээгүй хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан


байна.

1.1.10 “Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл худалдаа үйлчилгээ, хөрөнгө оруулалт, дэд бүтэц, боловсрол, соёл, урлаг, эрүүл мэнд зэрэг салбаруудын бодлого шинэчлэлийн хүрээнд 143 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 17 төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.

1.1.11 Үүнээс хөдөө аж ахуй, соёл урлагийн бодлогын үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхээр 2 төсөл арга хэмжээг аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр, засаглалын бодлогын үндсэн чиглэлийн хүрээнд замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 15 төсөл, арга хэмжээг баталсан байгаа бол аймгийн ЭЗНХҮЧ-ийн бусад бодлогыг хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөж батлаагүй байна.

1.1.12 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан төсөл арга хэмжээг шинж чанараар нь ангилан дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №2 / сая төгрөг /



Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол

1.1.13 Дээрх дүрслэлээс харахад 2018 онд машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авах төсөл арга хэмжээ 2018 онд нийт хөрөнгө оруулалтын 14,6 хувийг эзэлж байсан бол 2019 онд 22,6 хувь, 2020 онд 18,8 хувь болж өссөн байна.

Дүрслэл №3 / төсөл, арга хэмжээний тоогоор /



Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол

1.1.14 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сүүлийн 3 жилд нийт 352 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 179 төсөл, арга хэмжээ буюу 51 хувийг тоног төхөөрөмж худалдан авах, 106 төсөл, арга хэмжээ буюу 30 хувийг их засварын ажил, 67 төсөл, арга хэмжээ буюу 19 хувийг барилга, байгууламж эзэлж байна. Тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээ нь нийт төсөл, арга хэмжээний 2018 онд 62 хувь, 2019 онд 29 хувь, 2020 онд 41 хувийг тус тус эзэлж байна.

1.1.15 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд барилга угсралт, их засвар зэрэг бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг бус машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авах төсөл арга хэмжээг түлхүү байдлаар тусгаж байгаа болон нийт төсөл арга хэмжээний /Замын сангийн хөрөнгө оруулалт ороогүй/ 37.0 хувийг 10.0 сая төгрөг болон түүнээс доош төсөвт өртгөөр хэрэгжүүлэх, хэт жижиглэсэн төсөл арга хэмжээ эзэлж байгаа нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна. /Хавсралт №6-д дэлгэрэнгүй харуулав/

1.2 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ТЭЗҮ, зураг, төсөв нь иж бүрэн хийгдсэн, шаардлага хангасан төсөл, арга хэмжээг тусгаж батлуулсан уу?


Тооцоо судалгааг урьдчилан хийгээгүй, зураг төсөвгүй, зураг төсөвт магадлал хийлгээгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

1.2.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2020 онд шинээр хэрэгжих 3,284.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 92 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 1,641.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 55 төсөл, арга хэмжээний зураг төсөв, тооцоо судалгааг төсөв батлахаас өмнө хийсэн бол зураг төсөв, тооцоо судалгаагүй 1,642.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 37 төсөл, арга хэмжээг баталсан байна.

1.2.2 Үүнээс аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 125.0 сая

төгрөгийн төсөвт өртөгтэй 4, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1,075.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 зэрэг нийт **1,200.1** сая төгрөгийн төсөвт өртөгтэй **21** төсөл, арга хэмжээг тооцоо судалгааг урьдчилан хийгээгүй, зураг төсөвгүйгээр төсвийн тодотголоор нэмж баталсан бол **442.3** сая төгрөгийн төсөвт өртөгтэй **16** төсөл, арга хэмжээний зураг төсөв, тооцоо судалгааг төсөв батлагдсанаас хойш батлагдсан төсөвт өртөгт нь багтаан гүйцэтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4¹, 68.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. /Хавсралт №3, 4-д дэлгэрэнгүй харуулав/

Дүрслэл №4 / сая төгрөг, төсөл, арга хэмжээгээр/



Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол

1.2.3 Төсвийн тодотголоор тооцоо судалгааг урьдчилан хийгээгүй, зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмж баталж байгаа нь худалдан авах ажиллагаа оройтох, төсөл арга хэмжээ он дамжих буюу огт хэрэгжихгүй байх эрсдэлийг дагуулж байна.

1.2.4 2020 онд шинээр хэрэгжүүлэх нийт 1,161.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээнд ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөл, өртгийн төсвийг боловсруулж, магадлал хийлгэх ёстой байтал барилга угсралтын 2, сантехникийн их засварын 4, авто замын 2, зураг төсвийн 1, нийт 1,011.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээний зураг төсөл, төсөвт магадлал хийлгээгүй байгаа нь Авто замын тухай хуулийн 19.2.5², Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 6.3³ дахь заалтыг зөрчсөн байна. /Хавсралт №5-д дэлгэрэнгүй харуулав/

1.2.5 Хөрөнгө оруулалтын бус урсгал зардлын шинж чанартай, тухайн байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой 40.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 урсгал засварын ажлыг баталж хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д “Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж,

¹ Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”

² Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд эрх бүхий этгээдээр магадлал хийлгэж, дүгнэлт гаргуулан баталгаажуулсан байх.

³ Барилгын тухай хуулийн 25.2, 25.3, 25.5-д заасан зураг төсөлд магадлал хийнэ.

тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ” гэж заасныг зөрчсөн байна. Үүнд:

Хүснэгт 2 /сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг
1	Түшиг сумын орон нутгийн судлах танхимын шугам засвар	17.0
2	Цагааннуур сум ЕБС гадна талбайн тохижилт	10.0
	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын дүн	27.0
3	Орхон сумын Бэлэндалай багийн байрны гадна тохижилт	3.3
4	Сүхбаатар сумын тоглоомын талбайнуудыг засварлах	10.0
	Сумдын төсвийн хөрөнгө оруулалтын дүн	13.3
	Дүн	40.3

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор батлагдсан төсөл арга хэмжээ

Хоёрдугаар бүлэг

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр ашигтай байна уу?

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 1,935.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 38 төсөл, арга хэмжээ дутуу болон огт хэрэгжээгүй байна.

2.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан уу?

Тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

2.1.1 Аймгийн замын сангийн хөрөнгөөр 2020 онд 811.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/462 дугаар захирамжаар 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээний эрхийг сумдын Засаг дарга нарт шилжүүлж, гүйцэтгүүлсэн байна. /Хавсралт №7-д дэлгэрэнгүй харуулав/

2.1.2 Аймаг, сумдын төсвийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар 2020 онд 3,284.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 92 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталснаас тайлант онд хэрэгжсэн нээлттэй тендер шалгаруулалтаар болон харьцуулалтын аргаар болон зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах 1,673.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. /Судалгаа № 1-т дэлгэрэнгүй харуулав /

2.1.3 Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 39 төсөл, арга хэмжээнээс 1,017.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-

ын аргаар, 641.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг зөвлөх үйлчилгээний журмаар сонгон шалгаруулж, 235.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна. /Судалгаа № 1-т дэлгэрэнгүй харуулав/

Дүрслэл №5 /сая төгрөг, төсөл, арга хэмжээ/



Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны баримтууд

2.1.4 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 13 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны “Үнэлгээний хороо”-г аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бол сумдын хувьд “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнийг төсөл, арга хэмжээ тус бүрээр байгуулаагүй байна. Тухайлбал:

Цагааннуур сум 2020 онд 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг 2 удаа томилсон бол Сүхбаатар сум 3 төсөл, арга хэмжээний үнэлгээний хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг давхардуулан томилсон байна.

2.1.5 Үнэлгээний хороо болон ажлын хэсэгт томилогдсон нийт 218 /давхардсан тоогоор/ гишүүнээс 26 нь ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж, гарын үсгээр баталгаажуулаагүй байна.

2.1.6 Орон нутгийн төсвийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн, нээлттэй тендер шалгаруулалт, харьцуулалтын болон зөвлөх үйлчилгээний аргаар худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 1,673.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 төсөл, арга хэмжээний тендерийн баримт, бичгийг Сангийн сайдын тушаалаар батлагдсан жишиг баримт, бичгийн дагуу боловсруулж, худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд мэдээлсэн байна. /Судалгаа № 1-т дэлгэрэнгүй харуулав/

2.1.7 Аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 28.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг үндэслэлгүй боловсруулсан, тавигдах шаардлагыг бүрэн тусгаагүй байгаа нь ТБОНӨХБАҮХА

тухай хуулийн 11.1⁴, 19.2⁵, 48.3⁶-т заасныг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- “Шаамар сумын Дулаанхаан тосгоны захирагчийн албанд автомашин авах” 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний саналыг Дулаанхаан тосгоны Захирагчийн албанаас Тоёота, Аллион машин худалдан авах захиалга өгсөн боловч аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс техникийн тодорхойлолтыг Тоёота, Королла Аксио болгож өөрчилсөн байна. Уг автомашиныг Upegui.mn цахим хуудаснаас судлахад 14.0-17.5 сая төгрөгийн үнэтэй байна.
- “Сүхбаатар суманд Хогийн пункер худалдан авах” 8.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, төсөл, арга хэмжээний урьдчилсан тооцоо судалгааг хийгээгүйгээс гүйцэтгэх ажлын хэмжээ, багтаамж зэргийг тусгаагүй байна.

2.1.8 Аймгийн төсвийн болон замын сангийн хөрөнгө оруулалтын 35.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Үүнд:

- “Аймгийн ЗДТГ-т автомашин авах” 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтод “зүүн” жолооны хүрдтэй автомашин нийлүүлэхээр тусгагдсан байхад “баруун” жолооны хүрдтэй автомашин санал болгосон УАЗ мега ХХК-ийг шалгаруулсан,
- “Хушаат сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ замын гэрэлтүүлэг” 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр 2018 онд байгуулагдсан, татварын албанд Х тайлан гаргадаг, зам барих, завсар, арчлалтын тусгай зөвшөөрөлгүй, ажиллах боловсон хүчний болон техник хэрэгслийн нөөцгүй “Баян булагт тал” ХХК-ийг сонгон шалгаруулсан байна.

2.1.9 Тухайн онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, тайланг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.10⁷, 3.1⁸-д заасны дагуу аймгийн ОНӨГ хянаж, нэгтгэхээр зохицуулсан бөгөөд тус байгууллагын нэгтгэсэн тайланд дараах зөрчлүүд оршиж байна. Үүнд:

- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт дээр 210.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг илүү,

⁴ Захиалагч техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ дараах шаардлагыг хангасан байна”:11.1.2-д “үндэсний стандарт, техникийн шаардлага, норм, норматив, дүрэм, зааварт үндэслэх, үндэсний стандарт, техникийн норм байхгүй тохиолдолд Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн олон улсын стандартад үндэслэх

⁵ Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана.

⁶ “Төсвийн ерөнхийлөн захирагч ... худалдан авах бараа, ажил, үйлчилгээний захиалгыг төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийн хамт худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ”

⁷ Захиалагчийн боловсруулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан аргачлал, шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулна.

⁸ Төсвийн ерөнхийлөн захирагч ... нь тухайн онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг журамд заасан маягтуудын дагуу нэгтгэж бичгээр болон файлаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ... ирүүлнэ.

- Мандал, Сүхбаатар сумын 138.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээг дутуу,
- Баянгол, Жавхлант, Шаамар сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 299.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээг сумын хөрөнгө оруулалтаар тайлагнасан байна. /Хавсралт №8-д дэлгэрэнгүй харуулав/

2.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулсан уу?

Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 61.2 хувийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.2.1 Орон нутгийн төсвийн болон замын сангийн хөрөнгөөр 2020 онд 4,173.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 98 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 2,237.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 60 төсөл, арга хэмжээ бүрэн, 370.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн бол 1,565.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

2.2.2 Он дамжин хэрэгжих аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2, сумдын 3, замын сангийн 1, нийт 888.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээнд 2020 онд гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилт 474.3 сая төгрөгийг олгох төсөв баталснаас 3 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 384,6 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг олгосон бол 3 төсөл арга хэмжээнд төлөвлөсөн 89.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 3 / сая төгрөг /


№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн	Тайлбар
1	Шаамар сумын Дулаанхаан тосгоны захирагчийн албаны барилга	398.6	101.3	Санхүүжилтийг бүрэн олгосон
2	Сайхан суманд төрийн албан хаагчийн орон сууц худалдан авах	110.0	10.0	2020 онд санхүүжилт олгоогүй
3	Ерөө сумын Шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн зураг төсөв хийх	39.7	39.7	2020 онд санхүүжилт олгоогүй
4	Түнхэл 12 жилийн сургуулийн сургалтын хэрэгцээнд 12 ш компьютер худалдан авах	2.4	2.4	Санхүүжилтийг бүрэн олгосон
5	Сайхан сумын хот төлөвлөлтийн ТЭЗҮ хийлгэх	40.0	40.0	2020 онд санхүүжилт олгоогүй
6	Сүхбаатар суманд авто зам барих	298.2	280.9	Санхүүжилтийг бүрэн олгосон
Дүн		888.9	474.3	

Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримтууд

2.2.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймгийн замын сангийн хөрөнгөөр 2020 онд 3,284.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 92 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталснаас 1,538.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 57 төсөл, арга хэмжээ гэрээт хугацаанд бүрэн хэрэгжсэн байна. /Судалгаа № 2-т

дэлгэрэнгүй харуулав/.

Дүрслэл №6 / хувиар /



Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримтууд

2.2.4 Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоосонтой холбоотойгоор ажлыг хэрэгжүүлээгүй, гүйцэтгэл гараагүй, төсөл арга хэмжээний 2 дугаар багцад оролцогч материал ирүүлээгүй учраас 1 багц нь хэрэгжсэн, 2020 оны 12 дугаар сард худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас он дамжин хэрэгжихээр гэрээ байгуулсан зэргээс шалтгаалан 2020 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 5, Мандал сумын 1, замын сангийн 3, нийт 370.0 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна. /Судалгаа № 2-т дэлгэрэнгүй харуулав/

2.2.5 Аймаг, сумдын ИТХ-аас төсвийн тодотголоор төсөл, арга хэмжээг нэмж баталснаас худалдан авах ажиллагааг зарлахад хугацаа оройтсон, зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгч шалгараагүй, тооцоо, судалгаа, зураг төсөв боловсруулаагүйгээс худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй гэх үндэслэлээр тайлант онд шинээр хэрэгжих 1,375.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 26 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. /Судалгаа № 2-т дэлгэрэнгүй харуулав/.

2.2.6 Аймгийн ЗДТГ-ын СТСХ болон сумдын ЗДТГ-ын Санхүүгийн алба нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.9-д заасны дагуу төсөл, арга хэмжээ бүрээр захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, санхүүжилт хүссэн материалыг хянаж, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгосон байна.

2.2.7 Зураг төсөв, тооцоо судалгаа иж бүрэн боловсруулсан төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган баталдаггүйгээс аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2, Мандал сумын 1, Цагааннуур сумын 2, нийт 5 төсөл арга хэмжээний зураг, төсөвт тусгагдаагүй ажил буюу зайлшгүй хийх шаардлагатай нэмэлт ажил гарсан гэх шалтгаанаар 40.9 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан байна. Энэ нь тендер шалгаруулалтын үр дүнг бууруулж, сонгон шалгаруулалтаар шалгарсан төсөвт өртгийг нэмэгдүүлэх үндсэн шалтгаан болж

байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 4 / сая төгрөг /			
№	Төсөл, арга хэмжээ	Гэрээний дүн	Нэмэлт гэрээний дүн
1	Шаамар сумын Дулаанхаан тосгоны захирагчийн албаны барилга	398.6	26.3
2	Аймгийн ЗДТГ-ын үүдний довжооны засвар	2.9	2.9
3	Мандал сумын ЗДТГ-ын өргөтгөлийн барилгын сантехник засвар, хурлын заал 1 давхрын угтах үйлчилгээний хэсгийн засвар	136.8	10.0
4	Цагааннуур сумын ЗДТГ-т автомашин авах	34.8	0.2
5	Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгт зөөлөн эдлэл, тоглоом авах	18.5	1.5
Нийт дүн		591.6	40.9

Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримтууд

2.2.8 Сумдын ЗДТГ-ын Санхүүгийн алба нь гэрээний биелэлт, үр дүнг гэрээ дүгнэсэн маягтаар үнэлээгүй нийт 580.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн олгосон байна. Үүнд:

- Баруунбүрэн сум нь 28.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ,
- Баянгол сум нь 18.6 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ,
- Ерөө сум нь 60.1 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ,
- Мандал сум нь 300.1 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээ,
- Сайхан сум нь 18.1 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ,
- Сүхбаатар сум нь 62.2 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ,
- Цагааннуур сум нь 63.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ,
- Шаамар сум нь 30.3 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ.

2.2.9 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2, Ерөө сумын 1, замын сангийн 3, нийт 593.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний магадалшгүй ажлын зардалд 9.9 сая төгрөгийг хурлын тэмдэглэл, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэлийг үндэслэлгүйгээр олгосон нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9.16⁹ -д заасныг зөрчсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 5 / сая төгрөг /			
№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Магадалшгүй ажлын зардал
1	Түшиг сумын орон нутгийн судлах танхимын шугам засвар	17.0	0.3
2	Аймгийн ЗДТГ-ын үүдний довжооны засвар	28.1	0.5
3	Бугант Худалдааны төв, Цагдаагийн байрыг цэвэр бохир, халаалтын нэгдсэн шугамд холбох	17.0	0.3

⁹ Магадалшгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадалшгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэлийг үндэслэн олгоно.

5	Сүхбаатар суманд авто зам барих	298.2	4.9
6	Сүхбаатар суманд хатуу хучилттай зам барих	213.5	3.0
7	Сүхбаатар сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ замын гэрэлтүүлэг	20.0	0.3
	Дүн	593.8	9.3

Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримтууд

2.2.10 Сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, шууд худалдан авах аргаар гүйцэтгэх нийт 35.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулалгүйгээр 34.8 сая төгрөгийг харилцагч байгууллагад шилжүүлсэн байна. Үүнд:

- *Ерөө сумын цэцэрлэгт тоног төхөөрөмж худалдан авах /8.1 сая төгрөг/*
- *Ерөө сумын соёлын төвд ном худалдан авах /10.0 сая төгрөг/*
- *Ерөө сумын орон нутаг судлах танхимын тоног төхөөрөмж /10.0 сая төгрөг/*
- *Шаамар сумын Дулаанхаан тосгон “Ахмадын хороонд техник хэрэгсэл” худалдан авах /7.0 сая төгрөг/.*

2.2.11 Шууд худалдан авах босго үнээс давсан 33.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 2 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна. Үүнд:

- *Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн их засвар /20.2 сая төгрөг/*
- *Хүүхэд залуучуудын соёл , спорт цогцолборын дээврийг төмөрлөх /13.4 сая төгрөг/*

2.2.12 Сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 86.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээнд “Хүлээн авсан комиссын акт” үйлдэхгүйгээр 85.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 11.3¹⁰, 11.4¹¹-т заасныг мөрдөөгүй байна. Үүнд:

Хүснэгт № 6 / сая төгрөг /

№	Төсөл арга хэмжээ	Төсөвт өртөг	Олгосон санхүүжилт
1	Ерөө цэцэрлэгт тоног төхөөрөмж худалдан авах	8.1	8.1
2	Ерөө сумын Ойн менежмент төлөвлөгөө хийлгэх	15.0	15.0
3	Ерөө Соёлын төвд ном худалдан авах	10.0	10.0
4	Орон нутаг судлах танхимын тоног төхөөрөмж	10.0	9.7
5	Түнхэл 12 жилийн сургуулийн сургалтын хэрэгцээнд 12 ш компьютер худалдан авах	2.4	2.4

¹⁰ Их засварын ажлыг хийж дуусаад комисс ажиллан хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэлийг баримт бичгийн иж бүрдэлд хангана.

¹¹ Захиалагч худалдан авсан тоног төхөөрөмжийг комисс байгуулан тухайн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэл, Хавсралт №11-т заасан магтын дагуу тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үйлдэж санхүүжилтийн баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

6	Мишээл цэцэрлэгийн эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авах	9.4	9.4
7	Сүхбаатар сумын гудамжны гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ	4.5	4.5
8	Шаамар сумын Дулаанхаан тосгон “Ахмадын хороонд техник хэрэгсэл” худалдан авах	7.0	7.0
9	Шаамар сумын Дулаанхаан 3 дугаар цэцэрлэг “тоног төхөөрөмж, тавилга эд хогшил” худалдан авах	9.0	9.0
10	Шаамар сумын Дулаанхаан тосгоны ЭМТ-д тоног төхөөрөмж авах	7.0	7.0
11	Шаамар сумын ЕБС-т сургалтын хэрэглэгдэхүүн “Даралтат хөгжим” худалдан авах	3.8	3.8
Дүн		86.2	85.9

Эх сурвалж: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баримтууд

2.2.13 “Бугант Худалдааны төв, цагдаагийн байрыг цэвэр бохир, халаалтын нэгдсэн шугамд холбох” 17.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч “Уран төмөр хэлхээ” ХХК-д урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргалгүйгээр 6.8 сая төгрөгийг урьдчилан төлсөн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4¹², Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9.12¹³-д заасныг тус тус зөрчсөн байна.

2.2.14 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цагааннуур суманд зам тавих”, аймгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 298.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сүхбаатар суманд авто зам барих” ажлуудын гэрээний үнийн дүнгийн 5 хувь болох 19.9 сая төгрөгийг чанарын баталгаат хугацаанд барьцаалах нөхцөлийг гэрээнд тусгаагүйгээс санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2.2.15 “Сайхан сумын ЗДТГ-т ачааны автомашин авах” 16.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний тээврийн хэрэгслийн гэрчилгээг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй, “Шаамар сумын Дэлгэр хаан 1, 2-р баг замын зураг төсвийн үнэ” 3.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг бүртгэл, тайланд тусгаагүй байна.

2.2.16 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 61.2 хувь нь бүрэн хэрэгжиж бусад төсөл арга хэмжээ дутуу хэрэгжсэн буюу огт хэрэгжээгүй бөгөөд захиалагч байгууллагууд нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухайн жилд хүрэх зорилтот түвшин, үр дүнг тооцоогүй байна.

2.3 Гэрээний хэрэгжилтэд үр нөлөө бүхий хяналтыг хэрэгжүүлсэн үү?

Зарим төсөл, арга хэмжээний зураг, төсөвт зохиогчийн хяналтын гэрээ байгуулаагүй, ажил хүлээж авах комиссын бүрэлдэхүүнд зохиогчийг ажиллуулаагүй байна.

¹² Тендерийн баримт бичигт заагаагүй тохиолдолд захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.

¹³ Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно.

